

# Монголын Уламжлалын Нэгдсэн (Консерватив) Намаас 1996 оны УИХ-ын сонгуульд баримтлах мөрийн хөтөлбөр

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН (КОНСЕРВАТИВ) НАМ Монгол оронд нийгмийн шинэчлэл ардчилалын үйл явцыг тууштай гүнзгийрүүлэхийн тулд Монгол орныхоо үндэсний аюулгүй байдал, улс төрийн тогтвортой байдлыг хангах, ард түмнийхээ уламжлалт соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, зах зээлийн эдийн засгийн харилцааны механизмыг төлөвшүүлэх, нийгмийн шударга ёсыг баттай тогтоох, хүн амын нийгмийн хамгаалалтын түвшинг дээшлүүлэх бүх нийтийн үйлсийн төлөө 1996 оны УИХ-ын сонгуульд баримтлах мөрийн хөтөлбөрөө сонгогч танд толилуулж байна.

Сонгогч ТА БҮХЭН манай намд итгэл хүлээлгэсэнээр, Монголын Уламжлалын Нэгдсэн (консерватив) Намын «МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ТӨЛӨӨ» гэсэн үндсэн уриан дор хэрэгжих мөрийн хөтөлбөр нь улс орны өмнө тулгарч байгаа тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэх болно.

## ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР:

МУНН Монгол улсын эдийн засгийг сэргээх улмаар эрчимтэй хөгжүүлэх арга бол үндэсний үйлдвэрлэлийг бүх талаар бодитой дэмжих явдал гэж үзнэ. Эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний эдийн засгийн суурь болсон хөдөө аж ахуйн уламжлалт үйлдвэрлэлд түлхүү анхаарч улмаар үүн дээр үндэслэж импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг урамшуулах, үндэсний үйлдвэрлэл-шинжлэх ухаан, техник-технологийн цогцолборыг бий болгох дэс дараалсан тодорхой зорилтыг хэрэгжүүлнэ. Тухайлбал, хөдөлмөрийн нөөц багатай манай орны хувьд өндөр бүтээмжтэй, оюуны шингээлт багтаамж ихтэй дэлхийн дэвшилтэт техник-технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх явдлыг онцгой анхаарч, гадаадаас тэргүүний технологи, техник оруулахыг урамшуулсан бодлого явуулна.

Үйлдвэржүүлэх бодлого явуулахдаа Монгол орны байгаль, эдийн засгийн онцлогийг харгалзсан уламжлалт аж ахуйн хөрс сууринд тулгуурлан өндөр үр ашигтай үйлдвэрлэл бий болгохыг зорино.

Үндэсний үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн бүлэглэлүүд, өмчтөн төрөн гарах, эх орны эдийн засгийн хөгжилд тэдний зүгээс үзүүлэх нөлөөг хүчтэй болгохыг чухалчилж олон улсын зах зээлд гарахад нь тус дэм үзүүлнэ.

Үндэсний аж ахуйн нэгжүүд бие биеэ нөхөх, харилцан дэмжих чадварыг

95  
дээшлүүлнэ.

Улс орны банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг оновчтой өөрчлөн улс үндэснийхээ эрх ашигт нийцүүлэх, төгрөгийн ханшны уналт, тогтворгүй байдлыг арилгах арга хэмжээ авна. Хүн ам, аж ахуйн нэгжээс авах татварын хэмжээг боломжтой хамгийн доод хязгаарт барих, төсвийн аливаа илүү зарлага, сүйтгэлийг таслан зогсоох, алдагдлыг багасгах чиглэлийг баримтлана.

Намаас явуулах эдийн засгийн бодлого нь дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, өөрийгөө санхүүжүүлэх замаар хөрөнгө оруулах чадвар бүхий хувийн хэвшлийг түлхүү анхаарч энэ үндсэн дээр эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад чиглэнэ.

Тухайлбал, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд гадаад орнуудаас авч байгаа зээл тусламжийг төвлөрүүлэн Засгийн газрын банк байгуулан, төсөл шалгаруулж ил тод байдлаар хуваарилах, зээлийг үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэлбэрээр олгох явдлыг чухалчилна.

Төрийн өмчийн барилга байгууламжийг хувийнханд өндөр үнээр түрээслэх явдлыг эцэслэн, яам, тамгын газар, төсвийн байгууллагын эзэмшиж байгаа байшин барилгын ашиглалтыг сайжруулах, эзэнгүй өмчийн хувь хэмжээг бууруулах үүднээс хувийн хэвшлийн үйлдвэрлэлд зориулан хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах буюу үнэгүй шилжүүлэхэд анхаарна. Чингэхдээ нэмж хөрөнгө оруулах, шинээр ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээг төрийн өмч хувьчлалын комиссоос худалдан авагчидтай байгуулан тодорхой хугацааны турш нарийн чанд дагаж мөрдөнө.

Дотоодын үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн зориулалттай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг импортоор оруулахад гаалийн татвараас чөлөөлөх, бодлого баримтална. Орон сууцыг одоогийн эзэмшигчдэд нь үнэ төлбөргүй хувьчилна.

Мөнгө хадгалуулагчийн эрх ашгийг хамгаалахын тулд хадгаламжийн хүүгээс татвар авах явдлыг бүрэн зогсооно. Уудам дэлгэр газар нутаг, хүн амын нүүдэл суурьшил зэрэг Монгол орны өвөрмөц нөхцөлийг харгалзан аймаг, сумдын эдийн засгийн хөгжил жигд байх, тэдгээрийн бие биеэ харилцан нөхөх, дэмжих чадварыг сайжруулах чиглэлийг баримтална.

Эдийн засгийн хэлхээ холбоо, үүсэн хөгжиж нягтрах байдлыг харгалзан түүний бүсчлэл, дэд бүтэц, засаг захиргааны хуваарийг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Монгол орны хөгжлийн хөрс суурь болсон хөдөө нутгийг хөгжүүлэх төрийн үзэл баримтлалыг боловсруулан хэрэгжүүлнэ. Хөдөөд хүрэх зам, харилцааг онцгой анхаарч засмал замыг сайжруулах, шинээр тавих зэрэгт хөрөнгө, санхүүгийн боломж санаачилгыг зөвхөн төвд бус мөн орон нутагт нэгэн адил бүрдүүлнэ.

Хөдөөд сумын төв болон малчны хотыг цахилгаанжуулах, холбоожуулахад анхаарч, нар, салхи, усны гэх мэт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг түлхүү ашиглаж малчин өрхийн 60-аас доошгүй хувийг энэ чиглэлийн эрчим хүчээр хангана.

Хөдөө дэх бэлэн мөнгөний гачигдлыг арилгаж, малын хулгайг нийгмийн нийтлэг үзэгдлийнх нь хувьд бүрмөсөн таслан зогсооно.

Малчдын мал сүрэг, ургацын талбайг байгалийн гамшгаас хамгаалан нийгмийн даатгалд хамруулах, хөдөөд ажилгүй болсон худаг, услалтын системийг сэргээх, ажилд оруулах, шинээр байгуулах замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлж, малын бэлчээрийн эзэнгүйдлийг арилгах, хөдөөгийн сумдын мал эмнэлэг, үржлийн болон зоо-техникийн албыг бэхжүүлэх, мал сүргийн бүтэц, үдмын сангийн асуудлыг төрийн бодлогын хэмжээнд тавина.

Гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтарсан үйлдвэр байгуулахад анхаарахын зэрэгцээ Засгийн газрын шугамаар авч байгаа зээлийн хэмжээг үндэсний эдийн засгийн чадавхитай уялдуулан зохицуулж, зээлийг үр ашиггүй зарцуулах, үрэгдүүлж шамшигдуулах явдалтай шийдвэртэй тэмцэнэ.

Гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх эрх зүй, татвар, банк, санхүү, дэд бүтэц, үйлчилгээний бүхий л таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Аж ахуйн нэгж, хувийн компани, ганзагын наймаачдын зүгээс гадаад худалдаа эрхлэх үйл явцыг хөгжүүлэх чиглэлд төрийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Иргэд визгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарна.

### **ГАДААД ХАРИЛЦААНЫ ТАЛААР:**

МУНН нь Ази, Номхон далайн орнуудтай гадаад эдийн засгийн харилцааг хөгжүүлэхийн зэрэгцээ Европ, Умарт Америкийн орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлнэ. Манай нам дэлхий дахины болон бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн энхтайванч бодлогыг тууштай баримтална.

### **УЛС ТӨР, НИЙГМИЙН ХҮРЭЭНД:**

Монголын Уламжлалын Нэгдсэн (консерватив) Нам нь Монгол улс дахь ардчилсан төрийн тогтолцооны цаашдын төлөвшлийг парламентын бүгд найрамдах ёсны хөгжилтэй нягт холбон ойлгож өнөөгийн нийгмийн замбараагүй байдлалд эмх цэгц оруулахын эхлэл нь төр өөрөө эмх цэгцтэй болох явдал гэж үзнэ.

Төрийн үндсэн үүрэг нь үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг сахиулах явдал гэж үзэн бүх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг

орчимжүүлж, шүүх засаглалыг жинхэнэ утгаар нь бүрдүүлэн тогтооход чухалчлан анхаарна.

Төрийн албан хаагчдыг үнэлж сонгохдоо тэдгээрийн эрдэм чадвар зүтгэл, ёс суртахууны чанарыг чухалчлан үзнэ. Орон нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэн бататгана.

Парламентын олонхи, цөөнх болон парламентын бус намуудын бодлого, байр суурь төрийн үйл ажиллагаанд бодитой нөлөөлөх оновчтой бүтэц, механизмыг бий болгохыг зорино.

Монгол улсын хил, онц чухал объектийн хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг бэхжүүлэх, хууль, цэрэг, цагдаагийн байгууллагын ажилтнуудын үнэлгээ шалгуурыг төгөлдөржүүлж, түүнд нөлөөлөх эдийн засгийн хөшүүргийг боловсронгуй болгоно.

МУНН-ын нийгмийн бодлого нь Монгол улсын тусгаар тогтнол, нийгмийн шударга ёс, үндэсний уламжлалт ёс, заншил, соёлын хөгжил цэцэглэл, хүн ардын сайн сайхан аж амьдрал, уугуул монгол зан сургуулийн төлөө тэмцэхэд чиглэгдэх бөгөөд бүх нийтийн сайн сайхан аж байдалд хүргэх үндсэн арга зам нь нийгмийн гишүүдийн идэвхтэй хэсгийг дэмжиж авьяас чадвараа улс үндэстнийхээ сайн сайхны төлөө ашиглах, улс төр, эрх зүй, ёс суртахууны нөхцөлийг тууштай бүрдүүлэх явдал гэж үзнэ. Шударга бус аргаар хөрөнгөжих, баян хоосны хэт туйлшрал, нийгмийн эсрэг тэсрэг байдал бий болохоос сэрэмжилнэ.

МУНН-ын нийгмийн бодлогын үндэс нь Монгол улсын иргэн бүрт аж амьдралаа дархлах өргөн бололцоо олгох явдал гэж үзнэ. Монгол орны өвөрмөц нөхцөлийг харгалзан нийгмийн нийт гишүүдийн аж амьдралыг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг багасгахын тулд хүн амыг оновчтой суурьшуулах цогцолбор арга хэмжээ авна.

Монгол ёс заншил, суртахууны эх ундраа болсон хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийг хөнгөвчлөх, боловсрол мэдлэгээ дээшлүүлэх бололцоог хангахад онцлон анхаарна.

Өндөр настан, тахир дутуу хүмүүс, нийгмийн эмзэг хэсгийнхний тэтгэвэр, тэтгэмжийн ялгааг арилгах, алслагдсан бүс нутгийн хүн амын амьдрал-үйл ажиллагааны хөнгөлөлтийн системийг хэрэгжүүлэхэд анхаарна.

Эмэгтэйчүүдийн зүгээс гэр орон үр хүүхдэдээ хандуулах анхаарал, халамжийг нэмэгдүүлэхийн хамт эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хот, хөдөөгийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, орон нутгийг зохистой хөгжүүлж, хот суурин газрын хөдөөд үзүүлэх нөлөөг бүх талаар хүчтэй болгоно.

Монголын уламжлалт ёсыг баримтлан гэр бүлийг бэхжүүлэх, нийгмийн амьдралд түүний гүйцэтгэх үүргийг дээшлүүлнэ. Хүнсний аюулгүй байдал, эрүүл

ахуйн нөхцөлд тавих шаардлагыг дээшлүүлэн түүнийг зөрчигчдөд ногдуулах шийтгэлийг нэмэгдүүлнэ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдран суугаа олон ястны хөгжлийн жигд нөхцөл боломжийг хангах, хэл соёлыг хамгаалж хөгжүүлэхэд онцлон анхаарна.

**ОЮУН САНААНЫ ТАЛААР:**

МУНН нь монгол хүний сэтгэлгээ, амьдралын олон талт асуудалд хандах байдлыг хэзээнээс нааш тодорхойлж ирсэн «Эзэн хичээвэл заяа хичээнэ» хэмээн ажилсаг хичээнгүйг эрхэмлэх, «Санаа цагаан бол заяа цагаан» хэмээн бодол сэтгэлгээ зөв цэгцтэй байлгах, «Амны билгээс ашдын билэг» хэмээн бэлэг дэмбэрлийг дээдлэх, «Хүн ахтай дээл захтай» хэмээн ахмад настнаа хүндэтгэх, «Баян алтай хангай минь ивээ» хэмээн газар нутаг, хөх тэнгэртээ шүтэх, «Төрийн сүлд өршөө» хэмээн төрт ёсоо хүндэтгэн нөмөр нөөлгөнд нь багтахыг эрмэлзэх үзлийг нийгмийн оюун санааны амьдралын монгол төрхийг илэрхийлэх үндсэн зарчмууд гэж үзнэ.

Оюун санааны амьдралын эдгээр үндсэн зарчим, монгол суртахуунд түшиглэн иргэдэд орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэх, монгол хүнийг дэлхийн түвшинд чамлагдахгүй боловсрол, мэргэжил, техникийн соёлтой байх нөхцөлийг бүрдүүлнэ. Үүний тулд юуны өмнө нэгэнт бүрэлдэн тогтсон боловсрол шинжлэх ухааны тогтолцоог өөд нь татаж авах нь чухал гэж үзэж намаас энэ чиглэлд хөгжлийн цэгцтэй бодлого боловсруулж явуулна.

Нийгмийн шинжлэх ухааныг шинэчлэх үндсэн дээр ардчилал, зах зээлийн шаардлагад тохирсон мэдлэгийг дэлгэрүүлэх, улмаар иргэдийн улс төрийн ардчилсан ёсыг төлөвшүүлэхийг чухалчилна, Үндэсний соёл урлаг хөгжүүлэхэд онцгой анхаарахын зэрэгцээ дэлхий дахины соёл урлагийн шилдэг бүтээлүүд, өв санг ард түмнийхээ хүртээл болгоход хүч чармайлтаа чиглүүлнэ. Соёл урлагийг хүчирхийлэл, садар самууныг сурталчлах хэрэгсэл болгон хувиргахыг эрс буруушаана.

Нам иргэдийн шүтэн бишрэх эрх чөлөөг хүндэтгэн төр сүм хийд тусгаар байх зарчмыг баримтална.

Бурхны шашны зонхилох байр суурь болон Монголд иргэд бусад шашны шүтлэгтэй байхыг хүлээн зөвшөөрөхийн хамт, тэдгээрийн харилцаа, улс үндэстний сайн сайхны төлөө хамтын ажиллагааг зохицуулах арга хэрэгслийг бий болгох нь чухал гэж үзнэ.

Монголын Уламжлалын Нэгдсэн Нам хувь хүний мэдлэг, чадвар, овсгоо, самбаа зэрэг шинж чанарыг үнэлэн үзэж хөхүүлэн сайшаана. Халуун эх оронч байж, өрх гэр, ажиллаж байгаа үйлдвэр, албан газрынхаа сайн сайхан байдал, хөгжил цэцэглэлийн төлөө хүч чадлаа дайчлан ажиллах нь монгол хүн бүрийн

үүрэг, нэр төрийн хэрэг гэж үзнэ.

\* \* \*

МУНН өөрийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө улс төрийн сонгодог үзэл консерватизмын үндсэн зарчмуудыг Монгол орны өнөөгийн тодорхой нөхцөл байдалд бүтээлчээр авч хэрэгжүүлэх оролдлого хэмээн үзэж, улс төрийн бусад нам хүчинтэй санал нийлэх аливаа асуудлаар нягт хамтран ажиллана.

**МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН (КОНСЕРВАТИВ)  
НАМЫН УЛС ТӨРИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
V ХУРАЛДААН**